

## Хянах комисс

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Төв аймаг Улаанбаатар хотын захиргааны нутаг дэвсгэрийг нэгтгэн Улаанбаатарт төвлөрүүлэх, Улаанбаатар хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг 10 дугаар сарын 1-нд хийх, сонгууль хийсний дараа Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааны нутаг дэвсгэрийг нэгтгэн Улаанбаатарт төвлөрүүлэх, Улаанбаатар хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг 10 дугаар сарын 1-нд хийх, сонгууль хийсний дараа Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг татан буулгасанд тооцох, Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, цагдан сэргийлэх явдлын хэлтэс, улсын хянан байцаах бүртгэлийг эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1936 -4-3нд Сайд нарын Зөвлөлийн 20 дугаар хурлын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотын захиргааны дэргэд байгуулагдах **барилгыг хянах товчоо нь** барилгын ажлыг нэгдсэн нарийн бодлоготой явуулах. Үүний урьд томилогдсон Довчин даргатай **барилгын комисс** хэвээр үлдэж хотын **барилгын товчооны** ажлыг ерөнхийд нь хянан удирдах байвал зохионо гэжээ.

1939-3 сард хуралдсан Улсын 22-р бага хурлын тогтоолоор хотын захиргааг улсын яамдтай адил эрхий голгосон нь үл тохирох тул хотын яам хэмээхийг өөрчилж улсын дотор хотын захиргааны **нэгтгэсэн дүрмийг** зохиож гаргахыг УБХ-ын тэргүүлэгчид Сайд нарын Зөвлөлд даалгажээ.

1946 онд бүх аймаг, сум, баг, яам, газар байгууллагуудын тамга/ тэмдгийг шинэчлэн шинэ үсгээр болгож хийлгүүлж хэрэглүүлсэн байна.

1953-4-13-нд Сайд нарын Зөвлөлийн 117-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дэргэд байгаа секцүүдийг байнга ажиллах комисс болгон ажиллуулахаар тогтоожээ.

1959-1-28-нд Сайд нарын Зөвлөлийн 39-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны **санхүүгийн хэлтэст:**

- -Төсвийн тасаг
- -Орлогын тасаг

**Хянан байцаах** тасаг байгуулахаар тогтоожээ

1964-8-26-нд Сайд нарын Зөвлөлийн 391-р тогтоолоор сум, хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх хянах комиссын дүрмийг баталжээ.

1964-11-5-нд Сайд нарын Зөвлөлийн 488-р тогтоолоор Улаанбаатар хотын архитектурын газарт барилгын техникийн баримт бичгийн архив байгуулахаар тогтоожээ

1966-6-3-нд Сайд нарын Зөвлөлийн 205 дугаар тогтоолоор хотын дэвсгэр газарт байгаа ойн бүс, тарьсан мод, бут сөөг зүлэг зэрэг бүх төрлийн ногоон ургамлыг хот нийгмийн халдашгүй дархан фонд гэж үзэж, түүний ашиглалт үйлчилгээнд хяналт тавьж удирдах

хотын **ерөнхий төлөвлөгөөний** дагуу, засах сэлбэх өргөтгөх сайжруулах үүргийг аймаг, хотын захиргаадад хариуцуулжээ.

1968-12-6-нд сайд нарын Зөвлөлийн 398 дугаар тогтоолоор аймаг, хот, сум районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, орлогч, хариуцлагатай нарийн бичгийн дарга нарын ажлын хуваарийг батлаад 1961 онд баталсан хуваарийг хүчингүй болгожээ